

Байгууллагын удирдлагын мэдээллийн системийг боловсронгуй болгох асуудал

*МУИС-ийн ЭЗС-ийн Математик, компьютерийн тэнхим
багши, доктор(Ph), дэд профессор Д.Чимгээ*

Өнөө өдөр байгууллага хир зэрэг үр ашигтай ажиллах нь менежерийн мэдлэг чадвар, ажлын туршилага, арга барил, уди рдан манлайлж, зохион байгуулах авьяас чадвар, үйл ажиллагаандыа мэдээллийн технологийг нэвтрүүлэх, оновчтой шийдвэр гаргахад зүй зохистой мэдээллийн системийг ашиглахаас ихээхэн хамаарах болжээ.

Удир длагын мэдээллийн систем бол байгууллагын дэд системүүдийн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, бол овсон хүчинээр хангах, манлайлах, хянах явцад удирдлагын шийдвэр гаргалтыг бодитой мэдээллээр хангах систем юм. Энэ системийн үйлчлэх хүрээг судлаачид янз бүрээр авч үздэг. Зарим судлаачид байгууллагын уди рдлагын мэдээллийн системийн хүрээнд удирдлагын гурван түвшинг хамруулдаг байхад нөгөө хэсэг нь зөвхөн уди рдлагын түвшинг буюу дунд түвшний менежерүүдэд зориулсан дэд системүүдийг хамруулж үздэг. Манай орны хувь д байгууллагын удирдлагын бүтэц, зохион байгуулалтыг үйл ажиллагаа, удирдлага болон стратеги гэсэн гурван түвшинд тодорхойлж авч үздэг удирдлагын философийг баримтлах нь зүйтэй юм.

Зах зээлийн харилцаанд шилжссэнээр манай төр, олон нийт, бизнесийн байгууллагууд удирдлагын мэдээллийн систем ийг бүрдүүлэхэд ихээхэн анхаарч энэ чиглэлээр тодорхой алхмуудыг хийж эхэлсэн нь зохих үр дүнгээ өгч байна. Гэвч мэдээлэл нь тухайн цаг хугацаа, орон зайндаа бодитой байдаг тул мэдээллийг цуглуулах, нэгтгэх, бол овсруулах, дун шинжилгээ хийх, түүний дагуу зохицуулалт хийх, үр дүнг шалгах үйл ажиллагаа зарим байг ууллагын удирдлагын хүрээнд хангайттай хэрэгжсихгүй байна.

Байгууллагын удирдлагын үйл ажиллагаанд мэдээллийн техник, технологийг өргөн ашиглах, ялангуяа хэрэгцээтэй та йлан, мэдээг компьютержуулах, тоон шинжслэлийн аргуудыг ашиглан шийдвэр дэмжих системүүдийг бол овсруулах талаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлууд ихээхэн үгүйлэгдэж байна.

Удирдлагын мэдээллийн системийг боловсронгуй болгох асуудлыг судлахдаа менежментийн шинжлэх ухаан, түүнийг философиийг өөрийн орны хүн ам, нийгэм, улс төр, эдийн засгийн онцлогт тохируулан практик үйл аж иллагаанд эрчимтэй нэвтрүүлэх, зах зээл хөгжссөн орнуудын туршилагаас бүтээлчээр суралцах, мэдээллийн тухай ай үзэл баримтлал, дэлхийн хөгжлийн чиг хандлагыг баримтлан байгууллагыг системийн үүднээс авч үзэн түүний стратеги, зорилго, зорилтуудтай нийцүүлэх хэрэгтэй байна.

Орчин үеийн бизнесийн удирдлагын хөгжил нь даяарчлал, хүчтэй өрсөлдөөн, бизнесийн үйл ажиллагааны өөрчлөн байгуулалт, компьютерчисэн электрон ажлын байр, электрон арилжаа, электрон бизнес, мэдээллийн технологийн мэдлэгтэй ажилтнууд, мэдээлэл нөөц болсон зэрэг онцлог шинжүүдийг агуулж байгаа билээ. Манай улс дэлхий нийтийн хөгжлийн энэ чиг хандлагыг баримтлан удирдлагын шинжлэх ухааны шинэлэг чиглэлүүдийг өөрийн орны онцлогт тулгуурлан хөгжүүлэх, шинжлэх ухаан, технологийн дэвилийн ололтыг удирдлагын үйл ажиллагаанд өргөн нэвтрүүлж бизнесийг үр ашигтай удирдах нь зайлшгүй чухал болжээ. Монгол улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээр нийгэм эдийн засгийн харилцаа улам нарийн төвөгтэй болж, улмаар аль ч байгууллагын хувьд удирдлагыг боловсронгуй болгон хөгжүүлэх зорилтыг нэн тэргүүнд дэвшигүүлэн тавьж шийдвэрлэх нь чухал болов. Өнөөдөр байгууллага хир зэрэг үр ашигтай ажиллах нь менежерийн

мэдлэг чадвар, ажлын туршлага, арга барил, удирдан манлайлж, зохион байгуулах авьяас чадвар, үйл ажиллагаандыаа мэдээллийн технологийг нэвтрүүлэх, оновчтой шийдвэр гаргахад зүй зохистой мэдээллийн системийг ашиглахаас ихээхэн хамаарах болжээ. Байгууллагын удирдлагын үндсэн агуулга нь шийдвэр гаргалт билээ. Шийдвэр гаргалт оновчтой байх нь ашиглаж буй мэдээллийн бодит, үнэн зөв, цаг хугацаандыаа байх асуудалтай шууд холбоотой байна.

Дээрх асуудал бизнесийн төдийгүй бусад аль ч салбарын ямар ч байгууллагад хамааралтай болсон нь Монгол орны өнөөгийн нийгмийн хөгжлийн онцлог юм. Өнөөдөр аливаа байгууллагын удирдлагыг зах зээлийн орчинд нийцүүлэн шинчлэх, хөгжүүлэх шаардлагатай байгаа нь нийгмийн хэрэгцээтэй уялдаатай. Ямарч байгууллага бизнес эсвэл бизнесийн бус гэдгээс үл хамааран өөрийн зорилго, төлөвлөгөөтэй ажилладаг. Тавьсан зорилгоо хэрэгжүүлэхэд хэрэгцээтэй мэдээлэл нь цагтаа, үнэн зөв байх асуудал менежерүүдэд амин чухал юм. Менежерүүдийг ийм мэдээллээр хангаж чадах удирдлагын мэдээллийн системийг байгуулах, боловсронгуй болгох нь чухал байгааг байгууллагын удирдлага анхааралдаа авч, тодорхой төлөвлөгөө боловсруулж, зохих арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх цаг болжээ.

Удирдлагын мэдээллийн систем бол байгууллагын дэд системүүдийн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, боловсон хүчинээр хангах, манлайлах, хянах явцад удирдлагын шийдвэр гаргалтыг бодитой мэдээллээр хангах систем юм. Энэ системийн үйлчлэх хүрээг судлаачид янз бүрээр авч үздэг. Зарим судлаачид байгууллагын удирдлагын мэдээллийн системийн хүрээнд удирдлагын гурван түвшинг хамруулдаг байхад нөгөө хэсэг нь зөвхөн удирдлагын түвшинг буюу дунд түвшний менежерүүдэд зориулсан дэд системүүдийг хамруулж үздэг. Манай орны хувьд байгууллагын удирдлагын бүтэц, зохион байгуулалтыг үйл ажиллагаа, удирдлага болон стратеги гэсэн гурван түвшинд тодорхойлж авч үздэг удирдлагын философиийг баримтлах нь зүйтэй болов уу. Эдгээр түвшин бүрд гүйцэтгэх үүргүүдээрээ ялгаатай дэд системүүд нь бусад түвшний дэд системүүдтэй харилцан нягт уялдаатай ажиллаж, улмаар менежерүүдийг үнэн зөв мэдээллээр хангах боломжийг бүрдүүлэх учиртай. Ийм учраас байгууллагын удирдлагын мэдээллийн системийн хүрээнд удирдлагын бүх түвшний мэдээллийн дэд системүүдийг хамруулж, тэдгээрийг уялдуулан авч үзэх, энэ үзэл санааг баримтлан манай орны нөхцөлд асуудлыг судлан шинжилж боловсруулах нь илүү үр дүнтэй байх болов уу .

Зах зээлийн харилцаанд шилжсэнээр манай төр, олон нийт, бизнесийн байгууллагууд удирдлагын мэдээллийн системийг бүрдүүлэхэд ихээхэн анхаарч энэ чиглэлээр тодорхой алхмуудыг хийж эхэлсэн нь зохих үр дүнгээ өгч байна. Мэдээллийн үр ашигтай харилцаа холбоог тогтоох зорилгоор манай төр засаг, яам тусгай газруудыг холбосон засгийн газрын мэдээллийн сүлжээ 1998 онд байгуулагдсан билээ. Энэ сүлжээ нь мэдээллийн технологийн хэрэглээ болон мэдээллийг үйлдвэрлэх, тараах ажиллагааг дэмжихэд чиглэгдсэн бөгөөд одоо ч энэ үүргээ гүйцэтгэсээр байна. Түүнчлэн байгууллагын автоматжуулсан систем буюу "Ofimatic" системийг төр, засгийн газрын байгууллагуудад нэвтрүүлсэн байна. Энэхүү программыг ашигласнаар төрийн албан хаагчид электрон шуудан ашиглах, баримт бичгийг

хөтлөх, удирдах ажлыг түргэн шуурхай хийх боломжтой болжээ. Түүнчлэн яам, тусгай газар, боловсрол, үйлдвэр, аж ахуйн байгуулагуудад боловсон хүчин, санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн дэд системүүдийг эрчимтэй нэвтрүүлж байна. Сүүлийн жилүүдэд манай их, дээд сургуулиудад мэдээллийн системийг хөгжүүлэх талаар нилээд ажил хийгдэв. Тухайлбал 1998 онд монгол улсын их, дээд сургуулиудын дотоод сүлжээг холбосон □Эрдэмнэл□мэдээллийн сүлжээ анх КтМС дээр төвлөрөн байгуулагдсан бөгөөд өнөөдөр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулж байна. Их, дээд сургуулийн номын сангийн мэдээллийн системийг компьютержуулах ажлууд хийгдлээ. Сургалтын бүртгэлийн мэдээллийн санг байгуулах талаар нилээд сургуулиуд үр дүнтэй ажиллаж тодорхой амжилтанд хүрсэн байна. Жишээлбэл, МУИС-ын хэмжээгээр багшийн анкет, оюутны бүртгэл, үнэлгээний мэдээллийн сан байгуулж түүнийг сургууль, факультетууд өөрсдийн хэрэгцээнд зориулан ашиглах боломжийг бүрдүүлжээ. Энэхүү асуудлын хүрээнд ШУТИС-ийн КтМС-ийн хамт олон сургалтын бүртгэлийн мэдээллийн системийг мэдээллийн технологи ашиглан боловсронгуй болгож багш, оюутны мэдээллийн хэрэгцээг хангах талаар нилээд асуудлыг шийджээ.

Гэвч мэдээлэл нь тухайн цаг хугацаа, орон зайндаа бодитой байдаг тул мэдээллийг цуглуулах, нэгтгэх, боловсруулах, дүн шинжилгээ хийх, түүний дагуу зохицуулалт хийх, үр дүнг шалгах үйл ажиллагаа зарим байгууллагын удирдлагын хүрээнд хангалттай хэрэгжихгүй байна. Удирдлагын шийдвэр гаргалт нь уламжлалт арга барил дээр тулгуурлан явагдаж байгаагийн улмаас тухайн шийдвэр нь бодит амьдралаас хол, үндэслэл муутай, уялдаа холбоотой нэгж хэсгүүддээ цаг хугацаандаа хүрч чадахгүй байх, байгууллагын цаашдын хөгжил стратегийн төлөвлөлтөд зохих нөлөөллийг үзүүлж чадахгүй зэрэг сул талууд ажиглагдаж байна. Байгууллагын удирдлагын үйл ажиллагаанд мэдээллийн техник, технологийг өргөн ашиглах, ялангуяа хэрэгцээтэй тайлан, мэдээг компьютержуулах, тоон шинжлэлийн аргуудыг ашиглан шийдвэр дэмжих системүүдийг боловсруулах талаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлууд ихээхэн үгүйлэгдэж байна.

Удирдлагын мэдээллийн системийг боловсронгуй болгох асуудлыг судлахдаа менежментийн шинжлэх ухаан, түүний философиийг өөрийн орны хүн ам, нийгэм, улс төр, эдийн засгийн онцлогт тохируулан практик үйл ажиллагаанд эрчимтэй нэвтрүүлэх, зах зээл хөгжсөн орнуудын туршилагаас бүтээлчээр суралцах, мэдээллийн тухай үзэл баримтлал, дэлхийн хөгжлийн чиг хандлагыг баримтлан байгууллагыг системийн үүдиэс авч үзэн түүний стратеги, зорилго, зорилтуудтай нийцүүлэх хэрэгтэй байна. Энэ асуудлын хүрээнд дор дурдсан зарим онцлогуудыг харгалзан үзэх нь чухал байна. Үүнд:

1. Мэдээлэл нь зорилгод чиглэгдсэн, тодорхой бус байдлыг багасгах боломж олгодог, боловсруулалт хийгдсэн, удирдлагын шийдвэр гаргах үндэс нь болдог. Мэдээлэл бүхэн удирдлагад хэрэгтэй байдаггүй. Иймд үй олон мэдээллээс өөрт хэрэгцээтэй мэдээллээ олж авах нь менежерийн чадвараас ихээхэн хамаарна. Удирдлагын мэдээлэл нь захиргаа, удирдлагад үнэн зөв дамжигдсан, удирдаж байгаа объектын талаарх мэдээлэл, түүнийг хүлээж аваад тодорхой зорилгод нийцүүлэн боловсруулалт хийж, түүнд үндэслэн шийдвэр гаргаж энэ талаар эргээд удирдуулах объектод үйлчлэх зорилгоор дамжигдаж буй мэдээлэл юм.
2. Удирдлагын мэдээлэлд үнэн зөв, цаг хугацаандаа, товч, тодорхой байх хэрэгтэй. Мэдээллийн үнэн зөв нь объектын талаар авсан мэдээлэл нь бодит байдалтай хэр


зэрэг нийцэж байгаагаар илэрхийлэгдэнэ. Мэдээллийн цаг хугацаандаа байх шаардлага нь удирдлагын шийдвэр гаргах хугацаагаар тодорхойлогддог. Үүнийг томъёогоор илэрхийлбэл:

$$T_d = T_0 + \sum_{j=1}^n T_j \leq T_p$$

Энд: T_d нь шийдвэр гаргах хугацаа
 T_0 нь объектыг тодорхойлооос эхлээд удирдлагад мэдээлэл очих хугацаа
 T_j нь шийдвэр гаргахад хийж байгаа ј үйлдэлд зарцуулсан хугацаа
 T_p нь шийдвэр гаргахад шаардагдах боломжийн хугацаа

Мэдээллийн товч байх шаардлага удирдлагын шийдвэр гаргахад шаардагдах хамгийн бага мэдээлээр тодорхойлогдоно. Мэдээлэл тодорхой байх асуудал түүний эмх цэгцтэй, ойлгомжтой байхтай холбоотой. Дээрх шаардлагуудыг хангаагүй мэдээллийг үндэслэж гаргасан шийдвэрийн хэрэгжилт үр дүнтэй байж чадахгүйд хүрнэ.

3. Удирдлагын мэдээллийг зориулалт, эх үүсвэр, агуулгаар ангилах нь мэдээллийг зөв, оновчтой зохион байгуулах, удирдлагын үр дүнг дээшилүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм. Удирдлагын мэдээллийг дор үзүүлсэн байдлаар ангиж болно. Нөгөө талаас удирдлагын шийдвэрийг ч эдгээр үзүүлэлтүүдээр ангилах нь хэрэгцээтэй мэдээллийг бүрдүүлэх, боловсруулах, хэрэглэгчдийг хангах ажлыг зохион байгуулахад чухал нөлөө үзүүлнэ.



4. Удирдлагын мэдээллийн системийг системийн хандлагаар боловсронгуй болгох нь чухал юм. Байгууллагыг судлах сонгодог онол, хүний харьцааны онол, мэдээллийн онол зэрэгт үндэслэсэн системийн хандлага анх 1960-аад оноос эхэлж хөгжиж ирсэн гэж үздэг. Энэ хандлагын гол санаа бол хоорондоо уялдаатай дэд системүүдийн хамтарч бутгэсэн үр ашиг нь дэд систем бүрийн үр ашигийн нийлбэрээс их байна гэж үздэг. Урьд өмнө байгууллагын олсон үр ашиг өндөр байж чадахгүй байсан нь менежерүүд системийг бүхэлд нь, түүнчлэн дэд системүүдийг хооронд нь уялдуулж чадахгүй байсантай холбоотой хэмээн үзж тайлбарлаж байна. Өнөө үед системийн хандлагтуйгээр үй олон холбоос, хамаарлын мөн чанарыг тогтоож чадахгүй, түүнийг удирдах ч боломжгүй болж байна.
5. Менежерүүдэд нарийн төвөгтэй шийдвэр гаргахад нь туслах зорилгоор удирдлагын арга техникийд эрчимтэй хөгжиж байна. Жишээлбэл: сүүлийн үед шугаман программчлал, математик загварчлал болон бусад тоон аргуудыг компьютер дээр программчилж, тэдгээрийг шийдвэр гаргахад өргөн хэрэглэх болжээ. 1970- аад оноос эхлэн хөгжиж ирсэн загварчлал орчин үед удирдлагын шинжлэх ухааны гол хүчтэй хэрэгсэл болж байна. Загварыг бодит системийн зан төлөв дээр үндэслэн боловсруулж, практикт нэвтрүүлж, гарсан үр дүнг шийдвэр гаргахад ашиглах болов. Менежер мэдээ баримтыг загварт оруулан тооцоолол

хийж, бодолтын үр дүнг компьютерийн дэлгэцэнд текст графикийн хэлбэрээр харж байна. Менежерийн компьютертэй харьцах ажиллагаа дэлгэцээр дамжин асуулт-хариултын хэлбэрээр явагдах бөгөөд энэ нь энгийн, ойлгомжтой байх нь чухал юм. Менежер боломжит хувилбаруудыг тооцоолсны эцэст хамгийн өндөр үр дүнд хүргэх, оновчтой хувилбарыг сонгодог боллоо. Загварт зориулсан мэдээллийн санд стратеги, тактикийн шийдвэр гаргах зориулалттай удирдлагын тайлан, ажил гүйлгээ боловсруулалтын мэдээ, гадаад, дотоод эх үүсвэрээс авсан мэдээлэл байна.

6. Компьютергүйгээр мэдээллийг хурдан боловсруулах ингэснээр нарийн төвөгтэй олон асуудлуудыг шийдэхэд шаардагдах мэдээллээр цаг тухайд нь хангах боломжгүй болжээ. Байгууллагын мэдээллийн систем хэр зэрэг үр дүнтэй ажиллах нь компьютерийн техникийн хүчин чадлаас ихээхэн хамаарч байна.
7. Байгууллагын мэдээллийн системийн үйл ажиллагаа ашиглаж байгаа программуудаас шууд хамаарна. Компьютерийн программ хангамжийн хөгжлийн срөнхий чиг хандлага гэвэл өндөр түвшний, хэрэглэгч-найз гэсэн зарчим дээр хөгжиж байна. Энэ нь программ зохиогч нарын хөдөлмөрийн бүтээмжийг дээшилүүлэх, хэрэглэгчдийн мэдээллийн системийг ашиглах сонирхолыг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлж байгаа юм. Байгууллага программчлалын хэлийг сонгоходоо юуны өмнө хэн ашиглах вэ, юунд хэрэглэх вэ гэдгийг нарийн тогтоох хэрэгтэй. Түүнчлэн программчлалын хэлийг сурахад хялбар эсэхийг тооцох нь зүйтэй. Менежер байгууллагадаа хэрэгтэй программыг сонгож аваадаа тухайн программын давуу ба сул талуудын талаар мэдлэгтэй байх шаардлагатай. Мөн шинэ программыг ашиглах боловсон хүчний чадвар, тухайн даалгаврыг гүйцэтгэхэд программын үр өгөөж ямар байхыг бодолцох нь их чухал. Байгууллага нь программыг худалдаж аваадаа тухайн программ бусад байгуулагууд дээр хэр зэрэг өргөн тархсан, энэ чиглэлээр зөвлөлгөө өгдөг, үйлчилгээ үзүүлдэг байгууллага хэр зэрэг олон байгаа, худалдан авах зардал нь байгууллага өөрөө уг программыг боловсруулж, хөгжүүлэх зардаас хямд уу, үнэтэй юу гэдгийг тогтоох хэрэгтэй.
8. Мэдээллийн системийн зорилго нь шаардлагатай мэдээллээр цагт нь, үнэн зөв, товч байдлаар хангах, харилцан уялдсан мэдээллийг хадгалах зорилготой. Гэвч байгуулагуудад хэдийгээр сайн компьютер, программ хэрэгсэлтэй байгаад ядуухан мэдээллийн сантай бол энэ зорилго хэрэгжиж чадахгүй юм. Мэдээллийн ойлголт өөрчлөгдснөөр мэдээллийн системд хандах харьцаа ч өөрчлөгдсөн. Мэдээллийн систем нь 70-аад он хүртэл их хэмжээний тайлан мэдээллийг үр ашигтай хадгалах, боловсруулахад анхаарал хандуулж байсан бол орчин үед хэрэглэгчийг маш өргөн хүрээнд мэдээлэлд хандах боломжийг олгоход чиглэгдэж байна. Энэ шинэ хандлага нь файл зохион байгуулах шинэ техник, арга хэрэгслийн хэрэгцээг зүй ёсоор тавьж, үүний дагуу мэдээллийн сангийн арга зүй орчин үед эрчимтэй хөгжиж байгаа билээ. 1970- аад оноос эхлэн харилцаа холбооны технологи ба сүлжээнүүд хүчтэй хөгжиж, компьютерийн техник хэрэгслийн үнэ буурч байгаа нь мэдээлэл боловсруулах ажиллагааг илүү их хуваарилах боломжийг бүрдүүлэх боллоо. Өмнө нь гол компьютер төвлөрсөн маягаар боловсруулалт хийж, алслагдсан терминалыг мэдээллээр хангаж байсан бол өнөөдөр байгууллагууд алслагдсан газар компьютерүүдийг суурилуулан түүн дээр боловсруулалт хийх хандлага улам эрч хүчтэй явагдаж байна. Түүнчлэн алслагдсан цэгт байгаа компьютерууд нь төвлөрсөн мэдээллийн санг ашиглаж байсан бол одоо өөрсдийн дотоод мэдээллийн сангийн ашиглах

хандлагаа өссөөр байна. Хэрвээ мэдээллийг хамтран эзэмших, нэгтгэх, өөрчлөх, захиргааны нэгдсэн хяналт тавих боломжуудыг хангаж чадах тийм механизмыг боловсруулсан тохиолдолд төвлөрсөн мэдээллийн санг алслагдсан цэгүүдийн компьютерүүдэд хуваарилаж үр дүнтэй ашиглах боломж бүрдэх юм.

9. Компьютерт байгаа мэдээлэл устаж алга болох тохиолдол янз бүрийн шалтгаанаар нилээд гарч байгууллагад ихээхэн хохирол учруулж байгааг бид мэнднэ. Ийм учраас байгууллага мэдээлэл алдагдах боломжуудыг сайтар судалж шинжлэн, түүнээс урьдчилан сэргийлэх, гарсан хор уршгийг арилгахын тулд зохих арга хэмжээнүүдийг төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх шаардлагатай. Эдгээр арга хэмжээг шууд ба шууд бус аргаар авч хэрэгжүүлж болно. Шууд бус арга гэдэг нь юуны өмнө менежерийн манлайлах үүрэгтэй холбоотой юм. Менежер нь хариуцлагаа ухамсарласан, өндөр ёс суртахуунтай, сахилга баттай, удирдах чадвартай байх ёстой. Түүнчлэн байгууллагын соёл, хамт олны уур амьсгалаас мэдээллийн алдагдал хамаардаг. Шууд арга гэдэг нь мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах ажилтан, хэлтэстэй байх, түүнд хөрөнгө хүч гаргах гэсэн үг юм. Байгууллага мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нууцлалтын талаар дүрэм журам боловсруулах, хариуцлагатай хүмүүсийн ажил үүргийн хуваарийг гаргаж мөрдүүлэх, техник хэрэгслийн хадгалалт, ашиглалтанд хяналт тавих хэрэгтэй. Шууд ба шууд бус аргуудыг хослуулан хэрэглснээр илүү үр дүнд хүрэх боломжтой.
10. Нууц мэдээлэл гэдэг нь тухайн байгууллагын эрх ашигт нийцсэн, задрагдсан тохиолдолд хор хохирол учруулах мэдээлэл юм. Манай улс үндсэн хуулиндаа "Монгол улсын иргэн төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална" гэж заасан байдал. Байгууллага нь нууцаа өөрөө тодорхойлж энэ талаар дүрэм журам боловсруулан мөрдүүлэх талаар хөдөлмөрийн гэрээнд тусгаж өгөх нь зүйтэй. Нууцыг хадгалах асуудал тухайн хүний сахилга бат, ёс зүйн хүмүүжилтэй ихээхэн холбоотой юм. Байгууллага нь нууцыг задарч болох сувгуудыг судалж, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах шаардлагатай. Жишээлбэл нууцыг хамгаалахтай холбогдуулж байгууллага дээр нууцын эрхлэгч буюу ажилтанг ажилллуулах, ажлын байрыг хамгаалах, баримт бичгийг хамгаалах арга хэмжээнүүдийг авах хэрэгтэй. Сүүлийн үед манай улс төрийн хамгаалалтанд байх шинжлэх ухаан, технологийн нэгдсэн сан, компьютержсэн мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах талаар ихээхэн анхаарч хууль эрхийн актуудыг баталсан билээ.
11. Хөгжлийн эхэн үед ихэнх байгууллагын удирдлагын мэдээллийн систем нь доод түвшний менежерт үйлчилдэг байснаас энэхүү мэдээллийн системийг хариуцсан дарга нь санхүү хариуцсан даргын мэдэлд ажилладаг байв. Орчин үед удирдлагын бүх түвшний менежерүүдийг шийдвэр гаргахад нь туслах үүднээс мэдээллийн дэд системүүдийг уялдуулан нэгтгэж байгууллагын хэмжээнд, өргөн хүрээнд үйлчлэх нэгдсэн системд шилжүүлэх хандлагаа эрчимтэй хөгжиж байна. Энэ үед удирдлагын мэдээллийн системийг хариуцсан ажилтан нь шууд байгууллагын дээд удирдлагад захирагдах нь илүү үр дүнтэй байна. Үүнтэй холбоотойгоор, сүүлийн үед байгууллагад мэдээлэл үйлчилгээний хэлтэс байгуулагдаж түүний дарга нь шууд дээд удирдлагад ажлаа тайлагнадаг болжээ. Манай оронд мэдээллийн төв, мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс байгуулах

замаар ихэнх байгууллагууд энэ асуудлыг шийдэж байгаа нь байгууллагын удирдлага мэдээллийн системийг хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдол өгч байгааг харуулж байгаа юм. Байгууллага удирдлагын мэдээллийн системийг үр өгөөжтэй ажиллуулахын тулд, ялангуяа эхний үед зохих менежер, компьютер- техникийн ажилтан, системийн шинжээч, харилцаа холбооны мэргэжилтнүүдийг багтаасан ажлын хэсгийг ажиллуулах хэрэгтэй юм. Ийм бүтэц, бүрэлдэхүүнээр тодорхой төслийн багийг бүрдүүлж болно.

12. Удирдлагын мэдээллийн системийг боловсронгуй болгох асуудлыг шийдвэрлэхэд байгууллагын дээд удирдлагын дэмжлэг онцгой нөлөөтэй болохыг анхаарах нь чухал юм.
13. Удирдлагын мэдээллийн системийн гол цөм нь компьютер биш харин хүн юм. Хүн энэ системийг судалж, шинжилж, боловсронгуй болгож хөгжүүлдэг. Ийм учраас хэдийгээр сайн техник, программ хангамж, мэдээллийн сантай байгаад чадварлаг боловсон хүчингүйгээр энэ системийг үр өгөөжтэй ашиглахын аргагүй юм.

Ашигласан материал

1. АнаньеваТ.Н, ~Автоматизированные системы обработки и поиска информации в аппарате управления” 1990.
2. Гуржав.Л, Цэрэндорж.Д, Социалист үйлдвэрлэлийн удирдлагын шинжлэх ухааны үндэс, 1975
3. Дорж.Т, Үйлдвэрлэлийн удирдлагын процесс. Шийдвэр гаргах арга зүйн асуудал, 1987
4. Дорж.Т, Чимэд.Ү, Менежмент, 2000
5. Четвериков, Ревунков, Самохвалов ~ Базы и банки данных~ 1997.
6. Chimgoo.D, Seth Spaulding, *Educational management information system and benefit monitoring and evaluation consultancy*, 1999
7. Чимгээ.Д, Менежментийн мэдээллийн систем (сургалтын материал), 1998.
8. Charles W.Hill, Gareth R.Jones, *Ctrategic management theory*, 1995
9. Haynie W.J, Richard E. Peterson, *The technology of communication*, 1995.
10. Joseph W. Wilkinson *Accounting & Information System*, 1991.
11. James A.O'Brien, *Management information system: managing information technology in the networked enterprise*, 1996
12. Katz, Y.J., Offir B., *Information technology in educational management*, 1995
13. Kenneth C.Laudon, Jane Price Laudon. *Management Information System a Contemporary Perspective*. 1988
14. Merilyn Meyer&Roberta Baber, *Computers in your future*, 1997.
15. Менежмент. Удирдах ажилтан бизнес эрхлэгчдэд зориулсан сурх бичиг, 1997
16. Мэдээлэл холбооны технологийн үндэсний анхдугаар чуулганы материал, 1999.06.12-13
17. Наандэлгэр. Д, Удирдлагын ерөнхий онол, математик загварчлал, 1996

18. Robert G. Murdick, Joel E. Ross, James R. Cloggette *Information systems for modern management.*, PMI, 1992.
19. Richard E.Peterson, Haynie W.J, *The technology of communication*, 1995
20. Peter Norton□s, *Introduction to computers*,1995.
21. Sarah E.Hutchinson, Stacey C. Sawyer, *Computers, communications and information*, 1998
22. Williams Sawyer Hutchinson, Using information technology. *A practical introduction to computers&communication*, 1997.
23. <http://www.is2000.org> (Information system)
24. <http://spr.das.state.or.us/ors.htm/> (installation and use by state agencies of information and telecommunications technology; rules)
25. <http://www.raummer.com/> (Information technology management consulting)